

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫГ
ТОМИЛУУЛАХ АСУУДЛААРХИ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2017 оны 10 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Билэгт

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Содномын Чинзоригийг томилуулахаар 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа Ерөнхий сайдын дээрх саналыг хэлэлцлээ.

Содномын Чинзориг нь төлөвлөгч-эдийн засагч мэргэжилтэй, 1986 оноос хойш төрийн албанд ажилласан бөгөөд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд, Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байсан, тухайн ажил, үүргийг гүйцэтгэх мэдлэг, чадварыг эзэмшсэн.

Содномын Чинзоригийг Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.


Үүнтэй холбогдуулан Нямтайширийн Номтойбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн боловсруулж, “Засгийн газрын зарим гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулахаар тогтсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдыг томилуулах асуудлаархи Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХ-АМГАЛАН